

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.4 дэх хэсэг нэмсүгэй:

“38.4.Улсын Их Хурлын гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдлийг Улсын Их Хурлын цахим хуудаст нээлттэй байршуулах ба доорх мэдээллээс бүрдэнэ:

38.4.1.Улсын Их Хурлын дарга, гишүүний Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу гаргасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг;

38.4.2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.10, 10.11-т заасны дагуу гишүүний гаргасан мэдэгдэл.

38.5.Энэ хуулийн 38.4.1-т заасан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24.1.1-д заасны дагуу, 38.4.2-т заасан мэдэгдлийг Тамгын газар бүртгэж, хадгална.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гэр бүлийн гишүүд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг